*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

**ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ЛХАГВАДЭЛГЭРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадвахыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1 | Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцон эрсдэлийг бууруулах талаар авсан арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг тооцох, бууруулах чиг үүрэг нэмэгдсэн. | Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцож, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн байна. | Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 06 дугаар тушаалаар ГЕГ-ын даргын шууд удирдлага дор Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс байгуулагдсан бөгөөд тус тушаалын хавсралтын 3.3.7-д Дотоод хяналт, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж нь “ГЕГ – ын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, гаалийн байгууллагын холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх үндсэн үүрэг хүлээнэ” гэж заасныг үндэслэн ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын дарга нарт дээрх ажил, үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг хариуцсан нэгжид тайлагнах үндсэн үүрэг албан тушаалын тодорхойлолтод нэмэгдэж байгаатай холбогдуулан “Нэгжийн үйл ажиллагаанд гарч буй эрсдэлийг судалж, эрсдэлийн үнэлгээ хийх, гарах эрсдэл хохирлыг тодорхойлж, илрүүлэх, | 2024.04.01-2024.11.30 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох тайланг улирал бүр ирүүлэхийг” ажлын чиглэл болгосон 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 01-5/1741 дугаартай албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн. Гаалийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох зорилго бүхий санал асуулгыг нийт 19 газар, хороодын 1069 төрийн төрийн албан хаагчдаас авч нэгтгэсэн. | | |
| 2 | Аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалын дагуу шинээр нэмэгдсэн чиг үүрэг. | - Мэдээллийн болон программ хангамж, дотоод сүлжээний аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.<br>- Барилга байгууламж, хөдөлмөрийн болон албаны нууцтай холбоотой бүх төрлийн мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.<br>- Байгууллагын албан хаагчдын аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна. | Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 06 дугаар тушаалаар ГЕГ-ын даргын шууд удирдлага дор Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс байгуулагдсан бөгөөд тус тушаалын хавсралтын 3.3.7-д Дотоод хяналт, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж нь “ГЕГ – ын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, гаалийн байгууллагын холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх үндсэн үүрэг хүлээнэ” гэж заасныг үндэслэн ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын дарга нарт дээрх ажил, үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг хариуцсан нэгжид тайлагнах үндсэн үүрэг албан тушаалын тодорхойлолтод нэмэгдэж байгаатай холбогдуулан “Аюулгүй байдал хариуцсан албан хаагчийг томилж, байгууллагын барилга, байгууламж, гаалийн хяналтын техник хэрэгслийн ашиглалтад хяналт тавих, ашиглалтын хугацаа, эвдрэл гэмтлийн бүртгэл, мэдээллийн сан үүсгэж, холбогдох арга хэмжээ авах, албан хаагчдын аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулах, албаны нууцын жагсаалтад орсон мэдээллийг нэг цонхоор | 2024.04.01-2024.11.30 | 95 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлж, түүнд хяналт тавих, аюулгүй байдлыг хангаж холбогдох тайланг хагас жил, жилээр ирүүлэхийг" ажлын чиглэл болгосон 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 01-5/1741 дугаартай албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br><br>2024 оны 10 дугаар сарын 02 –нд ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад 24/102 тоот дотоод зурвасаар "Гаалийн байгууллагын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах журам" –ын төсөлд санал авахаар явуулсан.<br>2024 оны 10 дугаар сарын 03 –нд харьяа гаалийн газар хороодын дарга нарт 01-5/4033 тоот албан бичгээр "Гаалийн байгууллагын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах журам" –ын төсөлд санал авахаар явуулсан.<br>Журмын төслийн саналуудыг хүлээн авч нэгтгэн тус хэлтсийн ГУБ, ГУАБ, дарга нар хянаж эцсийн байдлаар бэлэн болгосон. | | |
| 3 | Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн хяналт, шийдвэрлэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл шалгагдаж шийдвэрлэгдсэн байна. Хэрэгжилтэд хяналт тавьсан байна. | 1. Замын-Үүд дэх гаалийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/255 дугаартай албан бичгээр ирүүлсэн тус газрын хяналт шалгалт хариуцсан ГУАБ Ж.М, ГУБ Л.Д нарт холбогдох гаалийн хяналт шалгалтыг дутуу хийж, бусдад гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон гэх материалыг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулж холбогдох материалыг бүрдүүлэн сахилгын хороогоор хэлэлцүүлэхээр шилжүүлсэн.<br>2. Замын-Үүд дэх гаалийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/255 дугаартай албан бичгээр ирүүлсэн тус газрын хяналт шалгалт хариуцсан ГУАБ Ж.М, ГУБ С.Ц нарт холбогдох гаалийн хяналт шалгалтыг дутуу хийж, бусдад гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон гэх материалыг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулж холбогдох материалыг | 2024.04.01-2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрдүүлэн сахилгын хороогоор хэлэлцүүлэхээр шилжүүлсэн.<br>3. АТГ №27 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийн дагуу СЭГГ-ын ГУАБ Э.Б, ГУБ Б.Т нарт ГЕГ-ын даргын 2024.05.15 Б/343, Б/344 тоот тушаалаар 3 сар цалингийн 20% хасах сахилгын шийтгэл ногдуулсан.<br>4. Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024.06.14-ний өдрийн 083 дугаартай “2024.03.22-ны өдөр ЗТГ-аас илрүүлэн бүрдүүлэлтийн бичиг баримтыг нягтлан шалгаж гаалийн үнийг дахин хянаж зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцох чиглэл өгсөн. БЦТ-ийн даргаас тус бүрдүүлэлтэд хариуцлага алдсан ГУБ-д хариуцлага тооцох зохицуулсан эрх мэдэл байхгүй тул ГУБ-ийн ажлын хариуцлага алдсан үйлдэлд дотоод хяналт шалгалтыг явуулан холбогдох арга хэмжээг авч бидний ажилд туслана уу” гэх дотоод зурвасаар ирүүлсэн асуудалд дотоод хяналт шалгалтын ажиллагааг явуулахад санаатай үйлдэл тогтоогдоогүй тул 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01-5/2760 дугаартай албан бичгийг ЗТГ, БЦТ-д хүргүүлсэн.<br>5. Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын ГУБ Б.Б-ийн гомдлын дагуу холбогдох хяналт шалгалтыг явуулахад 2024 оны 07 дугаар сарын 24-ний орой Хорио цээрийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Б.Б нь уг “ХоГГ-ын байцаагч нарын групп”-д хэрүүлийн чанартай зүйл бичсэн, энэ үйлдэл нь удаа дараа давтагдсан учир албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч гаалийн улсын ахлах байцаагч Н.Б-ын үүрэг болгосноор гаалийн улсын байцаагч Т.С нь “ХоГГ-ын байцаагч нарын групп”-ээс гаалийн улсын байцаагч Б.Б-ийг түр хугацаагаар хассан, ХЦХГУБ Б.Б нь өөрийн ажлын хуваарийг CAIS программд өөрийн эрхээр орж харах, тухайн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчаас асууж мэдэх боломжтой болох нь тус тус тогтоогдож, хэн нэг албан хаагчид хариуцлага | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцох эрх зүйн үндэслэл тогтоогдохгүй байх ба энэ талаар гомдол гаргагчид хариу мэдэгдсэн.<br>6. 2024.04.30-ны өдөр Замын-Үүд дэх гаалийн газрын Э-транс гаалийн хяналтын бүсэд А ХХК-ийн бараа тээврийн хэрэгсэлд дахин шалгалт хийхэд 15.703.513.71 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 7.851.756.76 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан нь баримтаар тогоогдож байх ба Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох шалгалтын материалыг сахилгын хороонд хүргүүлсэн.<br>7. 2024.06.15-ны өдөр ЗҮГГ-ын Дардан Ложистик" дахь гаалийн хяналтын бүсэд Н ХХК-ийн ... тоот мэдүүлэгт дахин шалгалтыг зохион байгуулж, тухайн аж ахуйн нэгжийн бараа тээврийн хэрэгслийг шалгаж, илэрсэн зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийж 42.323.150.26 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 21.161.560.13 төгрөгийн торгууль ногдуулж шийдвэрлэсэн ба Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох шалгалтын материалыг сахилгын хороонд хүргүүлсэн.<br>8. СЭГГ-ын лабораторид Ургамалын хорио цээрийн шинжээч С.Х-аас ирүүлсэн гомдол мэдээллийг хянан үзээд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Б/343, Б/344 дугаар тушаалаар Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын ГУАБ Э.Б, ГУБ Б.Т нарт албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн 27 дугаартай мэдэгдэлд Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын шинжээч ГУАБ Э.Б, ГУБ Б.Т, шинжээч С.Х нарын албан үүргийг түдгэлзүүлэх тухай тусгаагүй байсан тул гаалийн улсын байцаагчийн эрхийг түдгэлзүүлэх хууль зүйн үндэслэлгүй байх ба ДХАБХ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 24/91 дугаартай дотоод зурвасаар Хүний нөөцийн хэлтэст холбогдох арга хэмжээ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авахуулахаар тушаалын хуулбар, танилцуулгыг хүргүүлсэн.<br>9. 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн оройн 23 цаг 30 минутын үед Ханги дахь гаалийн газрын ГУАБ Б.Б нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ ГУАБ Ш.Г-тай муудалцсан мөн маргааш нь буюу 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн өглөөний 09 цаг 20 минутын үед дахин маргалдаж хоорондоо ноцолдож нэгэндээ гэмтэл учруулсан гэх мэдээллийн дагуу албаны хяналт шалгалтыг явуулж ГУАБ Б.Б, Ш.Ганбаярт цалингийн хэмжээг 3 сараар 20% бууруулах сахилгын шийтгэл тус тус ногдуулсан.<br>10. Хүний нөөцийн хэлтсийн 2024.09.19-ний өдрийн 245 дугаартай дотоод зурвасаар "Гаалийн улсын байцаагч Т.Б-ыг хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ бичиж өгөхийг удаа дараа шаардсан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа болно. Иймд "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм"-ийн дагуу шалгаж өгнө үү" гэх асуудлыг ирүүлсэн ба 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ГУАБ Т.Б-тай холбогдон хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ бөглөж өгөхийг сануулан холбогдох хууль, дүрэм, журмын талаар хэлж мэдэгдсэн. ГУАБ Т.Б нь 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ бөглөсөн.<br>11. ХНХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Б-ийн илтгэх хуудсанд бичиж ирүүлсэнд дотоод хяналт шалгалтын ажиллагааг явуулахад ГУБ Б.И нь бусдын талаар ярьсан болох нь тогтоогдож байх ба Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хуульд заасан албан хаагчийн хувийн мэдээллийг задруулсан үйлдэл тогтоогдохгүй байх тул 2024 оны 11 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүгээр сарын 22-ны өдөр 24/143 дугаартай дотоод зурвасаар хариуг хүргүүлсэн.<br>12. ШХГГ-ын хамт олноос ГЕГ-ын даргын нэр дээр ирүүлсэн "ШХГГ-ын дарга М.Ө, ГУАБ Д.Б нарт холбогдуулан гаргасан захидлыг хүлээн авч хянан үзээд захидалд дурьдагдсан асуудал нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байх тул 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01-5/4873 дугаартай албан бичгээр АТГ-т харъяаллын дагуу шилжүүлсэн. | | |
| 4 | Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээллийн шийдвэрлэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | - Гаалийн байгууллагын хэмжээнд албан шалгалтыг гүйцэтгэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.<br>- Шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцсон байна. | 1. Засгийн газрын 1111 төвд иргэн Б.О-аас ирүүлсэн гомдлыг хүлээн авч шалгахад иргэн, аж ахуйн нэгж нь мэдээллээ цахимаар авдаг болсон ба энэ талаар тухайн иргэнд тайлбарлаж хэлсэн боловч ойлгохгүй байснаас үл ойлголцох асуудал гарсан болох нь тогтоогдсон ба бичиг хэргийн ажилтан М.М, Б.Э нарт цаашид хэл ам асуудал гаргахгүй ажиллахыг анхааруулан үүрэг болгосон ба гомдол гаргагч Б.О-д холбогдох хариуг утсаар өгсөн.<br>2. ГЕГ-ын 1800-1281 дугаар утсаар иргэн Я-аас ирүүлсэн гомдлыг хүлээн авч шалган, бичиг хэргийн ажилтан М.М, Б.Э нарт цаашид иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн бичгийг хүлээн авч зохих газарт нь өгч байхыг үүрэг болгон, гомдол гаргагч иргэн Я-д холбогдох хариуг утсаар өгсөн.<br>3. ГЕГ-ын 1800-1281 дугаар утсаар 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр иргэн С.Ө-аас ирүүлсэн гомдлыг хүлээн авч хяналт шалгалтын ажиллагааг явуулж байна.<br>4. Иргэн С.О-оос ЧХОУНБГГ-ын ГУБ Ж.А-д холбогдуулан гаргасан гомдлыг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-5/2717 дугаартай албан бичгээр тус гомдлыг шийдвэрлүүлэхээр ЧХОУНБГГ-т шилжүүлсэн. Гомдол гаргагчид энэ талаар мэдэгдсэн.<br>5. Иргэн Б.Ц-ийн гомдлыг хүлээн авч хянан үзэхэд МУ-д тухайн бараа нь орж ирээгүй нь тогтоогдсон тул Цахимаар гомдол гаргасан Б.Ц-ийн дүү Б.С-д гомдлын хариуг мэдэгдсэн. | 2024.04.01-2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6. ГСГГ-ын ГУБ Г.С-ээс ирүүлсэн мэдээллийн дагуу хянаж үзэхэд шалгалтаар зөрчил илрээгүй тул 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 15-ны өдөр ГУБ Г.С-т хариу мэдэгдсэн.<br>7. Иргэн Ц.Э-ийн гомдолд холбогдох хяналт шалгалтыг явуулахад гомдол гаргагч иргэн Ц.Э нь өөрийн Viber хаягнаас 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 09 цаг 33 минутад гомдол санал барагдсан талаар гараар бичсэн бичигнийхээ зургийг авч ирүүлсэн тул гомдол санал барагдсан гэж үзэн гомдлыг шийдвэрлэсэн.<br>8. С У ХХК-ээс бичгээр ирүүлсэн ГУБ Л.Б, Д.Н, Г.О нарт холбогдох гомдлын дагуу Прокуророос хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоол ирсэн тул 2024.10.09-ний өдрийн 01-5/4142 дугаартай албан бичгээр гомдлын хариуг хүргүүлсэн.<br>9. Иргэн Н.Б-ээс гаргасан “ЧХОУНБГГ-ын албан хаагч нар нь ёс зүйгүй, зүй бус харьцсан” гэх гомдлын дагуу холбогдох хяналт шалгалтын ажиллагааг явуулахад 2024.11.21-ний өдөр Б нь Бээжин-Улаанбаатар чиглэлийн Ом-224 нислэгээр ирсэн ба 12 цаг 20 минутын үед ГУБ Б.Э нь иргэн Б-ний гар тээшинд ампултай тариа мэт зүйл байсан тул уг зорчигчийн ачааг нягтлан шалгах үед тариа биш үнэртэй ус гэээд чангаар загнаж, хараасан байх ба дотоод хяналт шалгалтаар гаалийн байгууллагын албан хаагч нар нь ёс зүйгүй, зүй бус харьцсан болох нь тогтоогдохгүй байна. 2024.11.25-ны өдөр ЧХОУНБГГ-т ажлын чиглэл хүргүүлэх тухай 01-5/4907 тоот албан бичгийг хүргүүлсэн болно. | | |
| 5 | Гаалийн байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалт хийх, гарсан үр дүнгээр зөвлөмж өгөх, | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | - Гаалийн байгууллагын хэмжээнд албан шалгалтыг гүйцэтгэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт | 1. ГЕГ-ын харьяа газар, хороодод 01-5/4907, 01-5/3584, 01-5/3541 дугаартай албан бичгээр нийт 3 ажлын чиглэл хүргүүлсэн байна. | 2024.04.01-2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцсон байдал | | | шалгалтыг хэрэгжүүлнэ.<br>- Шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцсон байна. | | | |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | , | Чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайланг хүргүүлсэн байна. | Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 06 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "ГЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн А/123 дугаар "Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалаар батлагдсан бүтцийн дагуу Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс байгуулагдсантай холбогдуулан "Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын төслийг шалгуур үзүүлэлтийн хамтаар боловруулсан ба ГЕГ-ийн газрын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, ГЕГ-ийн даргаар батлуулахаар хүлээгдэж байна. | 2024.04.01-2024.11.30 | 95 |
| 7 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнана. | Тайлант хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 2024 онд ГУБ-аар томилогдсон 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэн болон гаалийн байгууллагын албан хаагчаас нийт 18 тайлбар тодруулга авсан.<br>АТГ-т гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 1 мэдээлэл шалгуулахаар харьяаллын дагуу шилжүүлсэн байна. | 2024.04.01-2024.11.30 | 100 |
| 8 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | - Нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг таньж тогтоон, сан бүрдүүлсэн байна. Дүн шинжилгээ хийж, | Гаалийн байгууллага, албан хаагчтай холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэхтэй холбоотойгоор мэйлээр авч болох нэмэлт бичиг, баримт, тайлбар, фото зураг зэрэг мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах | 2024.04.01-2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрсдэл бууруулах арга хэмжээг тухай бүр авсан байна. | үүднээс үйл ажиллагаандаа албаны мэйл (****@customs.gov.mn) ашиглаж ажилласан.<br>- Нууцлал, аюулгүй байдлыг хангах шаардлагай албаны компьютерт хадгалагдаж байгаа болон цахимаар илгээгдэж байгаа мэдээлэлд түлхүүр үг хийж хэвшсэн. | | |
| 9 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | - Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.<br>- ГЕГ-ын ЗББНДБ болон ХГГХ-дод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | 1. 2024 оны эхний хагас жилийн байдлаар удирдлагаас өгсөн үүрэн даалгаврыг заасан хугацаанд биелүүлж ажилласан.<br><br>2. Тайлант хугацаанд АТГ-ын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 27 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийн дагуу СЭГГ-ын гаалийн улсын ахлах байцаагч Э.О, гаалийн улсын байцаагч Б.Т нарт тус тус сахилгын шийтгэл ногдуулах тушаал төлөвлөн батлуулсан байна.<br>3. Мөн дээрх хугацаанд 11 албан бичиг, 38 дотоод зурвас хүргүүлж ажиласан байх ба ҮАБЗ-д 1 санал хүргүүлсэн байна. | 2024.04.01-2024.11.30 | 100 |
| 10 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Ажлын цаг ашиглалтыг өмнөх оны мөн үеэс бууруулаагүй байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар ажлын цаг ашиглалтын хувьд өдөр тутамдаа өглөө болон орой цаг бүргэлд нүүр таниулж бүртгүүлсэн бөгөөд ажил тасалсан, ажлаас хоцролтгүй ажиллаж байна. 2024 оны 05 сарын 17-ны өдрөөс 2024 оны 05 сарын 31-ний өдрийн хооронд чөлөө авах хүсэлтээ Сегр программаар илгээн албан ёсоор чөлөө авсан болно.<br>2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл ээлжийн амралт эдэлсэн. | 2024.04.01-2024.11.30 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | - Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухай бүр орж ажилласан байна.<br>- Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл | Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухай бүр орж ажилласан.<br><br>Гаалийн байгууллагын албан хаагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлын талаарх мэдээллийг ГЕГ-ын Олон нийттэй харилцах албанд бичгээр гаргаж өгсөн. | 2024.04.01-2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.<br>- "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байууллагуудын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд гаалийн байгууллагын 2024 онд хийх ажлын дэд төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, үйлчилгээний стандарт, албан хаагчдын цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээрт тавих хяналтыг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор Гаалийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар, Дотоод хяналт аюулгүй байдлын хэлтсээс Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын албан хаагчын ажлын цаг ашиглалт, гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартад хяналт тавьж ажилласан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Шинээр батлагдсан хууль, журамтай танилцаж судлах, гаалийн байгууллагаас явуулсан урт болон богино хугацааны сургалтад хамрагдах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр<br>Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | | Монгол улсын Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Сургалтын төвийн “Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт”-д суралцаж төгсөн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ЧС 24/004 дугаартай гэрчилгээ авсан. | 2024.04.01-2024.11.30 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ……………………………… / Н.Лхагвадэлгэр/ 2024 оны 12 сарын 08

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НИНЖИЙН ЛХАГВАДЭЛГЭРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
НЭГЖИЙН НЭР: ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 4.** "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Дотоод хяналт, шалгалт хийх. | 56 | 10 | 66 | |
| 2. | Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх. | 56 | 10 | 66 | |
| 3. | Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх. | 55 | 10 | 65 | |
| 4. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт. | 60 | 10 | 70 | |
| 5. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадуур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт СЕРП программаар тухай бүр илгээж ажиллах. | 60 | 10 | 70 | |
| 6. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт. | 55 | 10 | 65 | |
| 7. | Үүрэг даалгаврын биелэлт | 55 | 10 | 65 | |
| 8. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх | 55 | 10 | 65 | |
| **Дундаж оноо:** | | | | 66.5 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх. | 90 | 12.5 | |
| **Дундаж оноо** | | | 12.5 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. Өргөдөл, гомдол шийдвэрлэлт | 6 | |
| **Дундаж оноо** | | 6 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *66.5* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 12.5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *8* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 93% |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс
*(албан тушаал)*

.............................
*(гарын үсэг)*

/Л.Очгэрэл/
*(албан хаагчийн нэр)*

2024.12.10 ............ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн гаалийн улсын байцаагч ................................ /Н.Лхагвадэлгэр/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.10 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ................................ / Г.Энхтайван /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

12/20 2024 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ГЕГ-ын хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсы ахлах байцаагч ................................ / Ө.Тэгшээ /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.20 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЕГ-ын дарга ................................ / Р.Отгонжаргал /
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*